

Дайн ба энх: үндэстний асуудал

Чингис хаан дэлхий дахинд энх амгаланг тогтоосон юм. Жувейни

Бүдрагчаагийн Даш-Ёндон, доктор (Sc.D)

Шинжлэх Ухааны Академи, Философийн хүрээлэн

Философийн салбар, Улаанбаатар, Монгол Улс

dashyondonb@mas.ac.mn, <https://orcid.org/0009-0002-4306-8841>

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комисс хамтран Олон улсын Энх тайвны өдрийг тохиолдуулан “Энх тайвнаар зэрэгцэн оршихуй: Орчин үе ба Монгол” эрдэм шинжилгээний томоохон бага хурал зохион байгуулав. (2029 оны 9 сарын 22). Бага хурлын илтгэлүүдийг эмхэтгэл болгож хэвлүүлэв.

Энэ бага хурлын талаар миний онцлон бичиж байгаагийн учир гэвэл:

а) Тус бага хуралд нэн олон, 22 судлаач эрдэмтэд тухайн сэдэвт холбогдох чухал санаа бодлоо илэрхийлсэн;

б) Илтгэгчид мөн сэдвээр санал бодлоо зөрүүтэйгээр илэрхийлсэн зүйл гараагүй, учир нь энхтайвны сайн сайхан, дайн дажингийн муу муухайгийн асуудлаар монголчууд бидний дунд ямар зөрөө зөрөлдөөн гарч болохсон билээ?!

в) Олон улсын дайн байлдааны эдүгээгийн явдлыг ажиглаад байхад нацизмын аюул гараад байгаа бололтой байна даа;

г) монголчууд бид монгол үндэстнээ ухааран хамгаалах санаа илтгэлүүдэд олон “өнцөг”-өөр тусгагдсан байна.

Түрүү үед, тодруулбал социалист, капиталист хоёр систем сэргөлдөн байсан үед “Энх тайвнаар зэрэгцэн оршихуй” сэдэв олон улсын харилцааг зохицуулахад чухал үүрэгтэй байсан: дэлхийн дайн байлдаанаас сэргийлэх. Гэтэл одоо үед ийм асуудал дахин яригдаж эхэлснийг тус бага хурлыг

зохион байгуулагчид соргоогоор анхаарчээ.

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссийн дэд ерөнхийлөгч, туршлагатай дипломат зүтгэлтэн С.Уянга, Философийн хүрээлэнгийн удирдлага Б.Пүрэвсүрэн, М.Анара, Ш.Ганхуяг, докторант П.Мягмарсайхан нартаа талархал илэрхийлье.

Тус хуралд танилцуулсан илтгэлдээ судлаачид маань ямар ямар нэн чухал санаа хэлснийг эшлэн авъя (эмхэтгэл хэн хүнд хүрээгүй нь мэдээж):

1. Тус хурлыг нээж хэлсэн үгэндээ Философийн хүрээлэнгийн захирал, доктор, профессор Б.Пүрэвсүрэн: Философичид энхтайвны асуудлыг зүгээр нэг нөхцөл байдал гэж үздэггүй, харин хүний ёс зүй, шудрага ёс, эрх тэгш байдлын үндэс суурь нь хэмээн ханддаг. Философи нь энх тайвны үзэл санааг нийгмийн ухамсарт гүн суулгах замаар түгээн дэлгэрүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг мэдлэгийн салбар юм гэдгийг онцлон тэмдэглэв.

2. Академич Б.Батхишиг “Олон улсын худалдааны дайн ба энх тайвны асуудал” илтгэлдээ: „ Улс хоорондын худалдааны зөрчил явсаар дайн тулаанд хүргэж байсан нь цөөнгүй” хэмээн анхааруулаад орчин үеийн дэлхий дахины нөхцөл байдлыг улстөрийн эдийн засгийн ухааны үүднээс шинжилжээ.

3. Доктор (Sc.D), профессор М.Гантуяа “Рерихийн тунхаглал ба түүний дэлхийн дахин болон Монгол улс дахь өнөөгийн түүхэн нөхцөлд үзүүлэх

ач холбогдол” илтгэлдээ: “XXI зууны энэ үеийн олон улсын зөрчилтэй нөхцөл байдал, улс төрийн хямрал, соёлын дурсгалт зүйлсийг эвдэн сүйтгэж болзолшгүй аюул занал-энэ бүхнээс үүдсэн соёлын өвийг хамгаалах асуудал нэн чухал болж байна” хэмээн тэмдэглэжээ.

4. Философийн ухааны доктор Б.Галиндэв “Энх тайвныг дээдэлсэн уран зохиолын дүрүүдийн тухай философи эргэцүүлэл” илтгэлдээ: “...урлаг, уран зохиол дайны үйл явцыг дурсаж, зураглаж, бичиж үлдээдэг учраас тухайн үеийн болон хойч үеийнхний үй олон уншигчдын сэтгэл санааг хөдөлгөн догдлуулж, хөөргөн сэргээж, уншигч өөрийнхөө дотоод сэтгэлд уран сайхны дүр хийсвэрлэн бүтээж, оюун санаандаа урт удаан хугацаанд хадгалан дурсан санаж, бодож бясалгах өргөн бололцоо олгодог” нь энх тайвны үйлсэд онц хэмээн цохон тэмдэглэв.

5. Доктор Б.Галаарид “Монголчуудын тэнгэр шүтлэг дэх амар амгалангийн үзэл санаа” илтгэлдээ: Мөнх тэнгэрийн ивээл дор Орчлонгийн жамыг сахиж, хэмиг үл алдагдуулан зүй зохистой амьдрах учиртай тухай үзэл нь хожим Рас Mongolica гэж нэрлэгдсэн тэрхүү улстөрийн практикийн оюун санаа-ёс зүйн суурийг бүрдүүлсэн билээ” гэсэн нь даян дэлхийн амар амгалангийн асуудалд монголчуудын оруулсан хувь нэмрийг тэмдэглэжээ.

6. Түүхийн ухааны доктор, генерал Ч.Сосорбарам “Батлан хамгаалах бодлого ба энхийг сахиулахуй” илтгэлдээ: “Өнөөгийн хүн төрөлхтөний хөгжил дэвшил нь улс хоорондын маргаантай асуудлуудыг дайн байлдаангүй, хүч хэрэглэхгүйгээр шийдэж чадах төвшиндөө бүрэн хүрсэн үү?...” гэдэг асуудлыг онцлон анхааруулжээ.

7. Доктор М.Мөнхзул, доктор Г.Уянга нар “Глобальчлал ба үндэсний үнэт зүйлсийн уялдаа” илтгэлдээ: “Глобальчлал үндэстнүүдэд ямар нөлөө үзүүлж байгаа вэ? гэсэн асуулт тавиад

энэ тухай дахь судалгааны дүнг нэгтгэж, глобальчлалын дүнд “Үндэсний үнэт зүйлээс татгалзах явдлыг ой санамжаа алдах, улмаар өөрийн гэсэн дахин давтагдашгүй байдлаа арилгахтай зүйрлэж болно” гэсэн нэн чухал дүгнэлт хийжээ.

8. Философийн ухааны доктор Ш.Ганхуяг, докторант Х.Амантай нар “Аристотелийн эв найрамдлын тухай ойлголт” илтгэлдээ, тухайн сэдвээрээ тус их сэтгэгчийн үзэл санааг шинжлээд энх тайвны онтологийг...гурван дүрсээр харуулаад, “эв найрамдлыг хуульчлах, шахах замаар бий болгож болдоггүй”..., энд ёс суртахуун гол үүрэгтэй хэмээн онцолжээ.

9. Доктор А.Энхбаяр “Ерөөл ба энхтайван” илтгэлдээ: “Хүн төрөлхтөн шинжлэх ухаан технологийн эдүгээгийн гайхамшигт ололт дунд бид асар том зөрчил, эмзэглэлтэй нүүр тулгарч” буйг сануулсан байна.

10. Доктор, профессор Б.Баатарсүрэн “Эх оронч үзлээр дамжуулан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхийг бэхжүүлэх нь” илтгэлдээ “...аюулгүй байдлын олон шинэ асуудлууд үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхи”-тай холбоотой болж байгааг онцолжээ.

11. Доктор Ж.Энхбаяр “Кантын үүрдийн энх тайван” илтгэлдээ: энэ хувь дахь “түүний үзэл санаа бол зүгээр нэг мөрөөдөл биш, харин урт хугацааны энх тайвныг эрх зүйн ба ёс зүйн үндсэн дээр байгуулах санал санаачлага байсан...” гэдэг дүгнэлт хийжээ.

12. Доктор Ж.Жаргалсайхан “XIII зууны монголчуудын даян дэлхийд энх тайвныг тогтоох бодлого” илтгэлдээ: энх тайвныг баталгаатай бэхжүүлэхэд “олон улсын харилцааны эрх зүйн орчинд дорвитой шинэчлэл хийх нь чухал” гэдгийг онцолжээ.

13. МЗЭ-ын шагналт, сэтгүүлч, дэд хурандаа Г.Баатарнум “Түүхэн үнэн цэргийн сонин энхийг сахиулах үйлсийг эхлүүлжээ” гэсэн илтгэлдээ дайн энхийн асуудлаар цэргийн хэвлэлүүдийн хэрхэн

анхаарал тавьдаг тухай чухал мэдээллүүдийг дурдан гаргажээ.

14. Философийн хүрээлэнгийн докторант П.Мягмарсайхан “Эв нэгдэл: нийгмийн гоо сайхны зарим асуудал” гэсэн өвөрмөц сонирхолтой илтгэлдээ энх тайвны асуудлаар зөвхөн гадаад тал төдийгүй тухайн нийгмийн дотоод талыг нь харгалзах ёстой, “нийгмийн гоо сайхан нь зөвхөн гадаад орчны эмх цэгц бус, харин шудрага ёс, эв нэгдэл, эрх тэгш байдал, хамтын үнэ цэнийн хэрэгжилтэнд оршдог” гэсэн дүгнэлт хийсэн нь, ер нь дэлхий дахины улс орнуудад ч холбогдох чухал санаа юм.

15. Философийн магистр Ж.Бямбасүрэн “Энх тайвнаар оршихуй ба боловсролын үнэт зүйл” илтгэлдээ: Энх тайвнаар оршино гэдэг нь зөрчил тэмцэлгүй, хүлцэнгүй оршиход бус, гол нь хамтын үнэ цэнэ, харилцан ойлголцол дээр суурилсан идэвхитэй амьдралын хэв маяг юм” гэсэн нь философижсон чухал дүгнэлт юм.

16. Философийн магистр О.Болор-Эрдэнэ “Сэтгэлийн амар амгалангаас мөнхийн энх тайван руу” гэсэн илтгэлдээ: энх тайван бол зөвхөн гүн ухаантнуудын мөрөөдөл төдий биш, харин бидний өдөр тутмын амьдралын амьсгал, ирээдүй оршихуй үндэс байх учиртай хэмээн онцоллоо.

17. Магистр, дэд хурандаа Д.Энхтайван “”Z” үеийн оюутан залуусын ёс суртахууны төлөвшлийн зарим асуудал” илтгэлдээ энэ

чиглэлээрээ хийсэн судалгааныхаа үр дүнг сонсгов.

18. Техникийн ухааны доктор Н.Тогтохын “Арга билгийн нэгдэл ба танин мэдэхүй” илтгэл цаад утгаараа даян дэлхийн энх тайвны байдалд холбогдсон байна.

19. Философийн магистр О.Мөнгөнсор “Эв зүйгээр зэрэгцэн оршихтой холбогдож болох шашны эксклюзивизм, инклюзивизм, плюрализм, релятивизм үзэл санаануудын тухай” илтгэлдээ бусад шашнууд харилцан ойлголцох асуудлыг онцгойлон хөндлөө.

20. Доктор Б.Цэрэнханд “Хүний оршихуйн гол мөн чанар нь энх тайван болох тухай асуудал” илтгэлдээ энх тайван бол хүн төрөлхтөний оршихуйн суурь зорилго бөгөөд философийн бүхий л хүрээний чухал асуудлын нэг юм хэмээн дүгнэжээ.

21. Эрдэм шинжилгээний ажилтан Ц.Ганбат “Монголын уламжлалт нүүдэлчин соёл ба НҮБ-ын энхийг сахиулах философийн уялдаа” илтгэлдээ энхийг сахиулах үйл ажиллагаанд философийн эвлэрэл ба итгэлцэл, хүний амьдралын үнэ цэнэ, тогтвортой хөгжил гэсэн тулгуур ойлголтууд хэрэглэгддэг гэжээ.

Илтгэлүүдийн эдгээр гол санаа юун дээр төвлөрөв гэдгийг л би анхаарсан юм. Юу гэвэл, илтгэлүүдийн нэр дурдсан санаа бүхэн Монгол үндэстэн-д ухааруулах сэтгэл, бодлыг нэг нэгдмэлээр илэрхийлсэнд оршино.